



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 05 сарын 28 өдөр

Дугаар А/223

Арвайхээр


Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.4.“в”, 29.2, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2019 оны “Аймгийн 2020 оны төсөв батлах тухай” 12/02 дугаар тогтоолын 5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн төсвийн хөрөнгөөр 2020 оны төсвийн жилд автозамын сангийн хөрөнгөөр санхүүжүүлэх 540,000,000 (таван зуун дөчин сая) төгрөгийн арга хэмжээний зардлыг хавсралтаар баталсугай.

2.Хавсралтад тусгагдсан хөтөлбөр арга хэмжээг худалдан авах ажиллагааны дагуу зохион байгуулахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (Н.Ганболд)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Г.ГАНБОЛД

011100497

Аймгийн Засаг даргын 2020 оны 05
дугаар сарын 05-ны өдрийн 7/2020 дугаар
захирамжийн хавсралт

2020 онд авто замын сангийн хөрөнгөөр санхүүжих
төсөл арга хэмжээний зардлын хуваарилалт

№	Төсөл хөтөлбөр, арга хэмжээний нэр	Төсөвт өртөг /сая төг/
1	Арвайхээр сумын авто замын хэвтээ тэмдэг тэмдэглэгээ	54.0
2	Арвайхээр сумын авто зам, явган хүний замын нөхөөс	70.0
3	Авто замын хагаралд ан цав хийх	20.0
4	Арвайхээр сумын гэрлэн дохионы шинэчлэл, замын хүнхэр толь, босоо тэмдэг тэмдэглэгээ	38.0
5	Хархорин сумын Хархорин музейн гаднах авто замын засвар	21.0
6	"Ундрах эрдэм" ХХК-ийн уулзвараас 403 дугаар орон сууц хүртэлх 116 метр урттай хатуу хучилттай автозам	59.0
7	Усан спорт сургалтын төвийн гадна авто зогсоол 490 м ²	29.0
8	Арвайхээр сумы 3 дугаар цэцэрлэгийн гадна авто зогсоол	27.0
9	Татварын хэлтсийн гадна автозогсоол 321м ²	21.0
10	Хайрхандулаан сумын Муруйн голын гүүрийн барилга угсралт	30.0
11	Хужирт сумын Шавар түрүүний голын гүүрийн барилга угсралт	35.0
12	Арвайхээр сумын 2,7 дугаар багийн үерийн суваг дээгүүр гарах гүүрийн барилга угсралт	10.0
13	Арвайхээр суманд шинээр баригдах автозамын зардлын зөрүү	126.0
	НИЙТ ДҮН	540.0

-oOo-